# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2021 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

# АГУУЛГА

**НЭГ**.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ....2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл....2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл....3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл....4
1.4 Бодлого, зохицуулалтын орчин....5
**ХОЁР**.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД....5
2.1 Статистик үзүүлэлтүүд....5
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд....7
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд....8
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд....9
**ГУРАВ**.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА....10
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар....10
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар....11
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар....11
3.4 Зээлийн чанарын талаар....12
**ДӨРӨВ**.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА....13
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар....13
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар....14
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар....15
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар....15
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар....16
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар....16
**ТАВ**.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА....17
5.1 ХЗХ-дын орлогын талаар....17
5.2 ХЗХ-дын зардлын талаар....17
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар....18
**ЗУРГАА**.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ....19
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар....19
**ДОЛОО**.ДҮГНЭЛТ....20

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2022.01.24 Улаанбаатар хот

## НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 209 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 ХЗХ буюу 16.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 44.5 хувь буюу 93 ХЗХ орон нутагт, 55.5 хувь буюу 116 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

*График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/*




Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 4 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 5 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 1 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх, 16 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 5 ХЗХ-ны 29 сонгуульт гишүүн болон гүйцэтгэх удирдлага, 2 нягтлан бодогч, 1 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

*Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл*

| Он | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021.IV |
|---|---|---|---|---|---|
| ХЗХ-дын тоо | 290 | 279 | 261 | 249 | 209 |
| Шинээр олгосон | 17 /1/ | 18 | 17 | 14 | - |
| Хүчингүй болгосон | 8 | 29 | 35 | 26 | 40 |
| Түдгэлзүүлсэн | 21 | 19 | 10 | 23 | 12 |
| Сэргээсэн | 4 | 7 | 1 | 6 | 1 |
| ТЗ-ийн хугацаа сунгасан | 54 | 100 | 52 | 49 | 85 |

*Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа*



## 1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 209 ХЗХ, 741 ажилтан, 75,400 гишүүн /75,199 иргэн, 201 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 8 дүүрэгт 116 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 ХЗХ буюу 21.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

*Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт*




Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 93 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд аймгуудад ХЗХ-д ихээр төвлөрсөн байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

*Зураг 3: ХЗХ-дын тархалт*




Тайлант улирлын байдлаар нийт 209 ХЗХ 63 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна.

Салбарын тархалтын хувьд 4 ХЗХ-ны 7 салбар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, 4 ХЗХ-ны 56 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд "Гялс төгрөг" ХЗХ-ны 52 салбар Баян-Өлгий аймгаас бусад 19 аймагт тархалттай байна.

*График 2:"Гялс төгрөг" ХЗХ-ны салбарын тархалт*



## 1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,749 гишүүн буюу 3.8 хувиар нэмэгдэж 75,400-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.3 хувь буюу 201 хуулийн этгээд, 54.8 хувь буюу 41,316 эмэгтэй гишүүн байна.

*Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл*




Нийт гишүүдийн 59.1 хувь буюу 44,575 гишүүн Улаанбаатар хотод бүртгэлтэй бол 40.9 хувь буюу 30,825 гишүүн орон нутагт бүртгэлтэй байна.

*График 3:ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/*




Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч гишүүдийн тоо тогтмол өссөөр байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын нийт гишүүдийн 12.9 хувь буюу 5,767 гишүүн "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд байгуулагдсан 56 ХЗХ-ны гишүүд байна.

Нийт 209 ХЗХ-ны 39.7 хувь буюу 83 ХЗХ 20-100 гишүүнтэй, 46.9 хувь буюу 98 ХЗХ 101-500 гишүүнтэй, 9.6 хувь буюу 20 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 3.8 хувь буюу 8 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

*График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл*




Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 8 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 47.8 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 2:ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар*

| Гишүүд /интервалаар/ | ХЗХ-ны тоо | Гишүүд | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 20-100 гишүүнтэй | 83 | 4,901 | 6.5% |
| 101-500 гишүүнтэй | 98 | 20,227 | 26.8% |
| 501-1,000 гишүүнтэй | 20 | 14,196 | 18.8% |
| 1,001-ээс дээш гишүүнтэй | 8 | 36,076 | 47.9% |
| Нийт | 209 | 75,400 | 100.0% |

## 1.4 Хууль тогтоомжийн өөрчлөлт

- Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага"-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, санал авахаар 2021.11.09-ний өдөр Хорооны цахим хуудаст байршуулж, 2021.12.13-ны өдөр МХЗХҮХ-ны гишүүн 78 ХЗХ, 2021.12.14-ний өдөр холбооны гишүүн бус 22 ХЗХ-ны төлөөллийг тус тус хамруулан цахим хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох саналуудыг тусгасан.
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар МХЗХҮХ-ны төлөөлөлтэй 2021.11.22-ны өдөр уулзалт зохион байгуулж хэлэлцүүлэг хийсэн.

# ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 209 ХЗХ-оос 2021 оны 4 дүгээр улирлын тайлангийн нэгтгэлд 14 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан.

## 2.1 Статистик үзүүлэлтүүд

*Хүснэгт 3:ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд*

| СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ | ХЗХ-НЫ НИЙТ ГИШҮҮД | | ҮҮНЭЭС: | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Улаанбаатар хот | | Орон нутаг | |
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| **ХЗХ-дын тоо** | **209** | **100.0%** | **116** | **55.5%** | **93** | **44.5%** |
| **Нийт гишүүдийн тоо** | **75,400** | **100.0%** | **44,575** | **59.1%** | **30,825** | **40.9%** |
| Эрэгтэй | 33,883 | 44.9% | 18,307 | 54.0% | 15,576 | 46.0% |
| Эмэгтэй | 41,316 | 54.8% | 26,131 | 63.2% | 15,185 | 36.8% |
| Гишүүн хуулийн этгээд | 201 | 0.3% | 137 | 68.2% | 64 | 31.8% |
| **Гишүүдийн насжилт** | **75,199** | **100.0%** | **44,438** | **59.1%** | **30,761** | **40.9%** |
| 18-35 насны | 23,182 | 30.8% | 15,299 | 66.0% | 7,883 | 34.0% |
| 36-45 насны | 21,576 | 28.7% | 12,845 | 59.5% | 8,731 | 40.5% |
| 46-55 насны | 17,478 | 23.2% | 9,337 | 53.4% | 8,141 | 46.6% |
| 55-аас дээш | 12,963 | 17.3% | 6,957 | 53.7% | 6,006 | 46.3% |
| **Гишүүдийн боловсрол** | **75,199** | **100.0%** | **44,438** | **59.1%** | **30,761** | **40.9%** |
| Дээд | 30,866 | 41.0% | 21,569 | 69.9% | 9,297 | 30.1% |
| Тусгай дунд | 13,051 | 17.4% | 8,708 | 66.7% | 4,343 | 33.3% |
| Бүрэн дунд | 22,233 | 29.6% | 12,883 | 57.9% | 9,350 | 42.1% |
| Дунд | 6,230 | 8.3% | 1,040 | 16.7% | 5,190 | 83.3% |
| Бага | 2,819 | 3.7% | 238 | 8.4% | 2,581 | 91.6% |
| **Нийт ажилтнуудын тоо** | **741** | **100.0%** | **456** | **61.5%** | **285** | **38.5%** |
| Үүнээс: эмэгтэй | 525 | 70.9% | 334 | 63.6% | 191 | 67.0% |
| **Санхүүгийн програмтай** | **94** | **45.0%** | **41** | **19.6%** | **53** | **25.4%** |

ХЗХ-дын нийт гишүүдийн 59.5 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс залуу байна.




*График 5: ХЗХ-ны гишүүдийн насжилт, УБ, орон нутгаар*

Нийт гишүүдийн 41.0 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр байна.

*График 6: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар*




*Хүснэгт 4:ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/*

| СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ | ХЗХ-дын нийт зээлдэгч | | ҮҮНЭЭС: Улаанбаатар хот | | ҮҮНЭЭС: Орон нутаг | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| **ХЗХ-дын тоо** | **209** | **100.0%** | **116** | **55.5%** | **93** | **44.5%** |
| **Нийт зээлийн үлдэгдэл** | **213,421,468.53** | **100.0%** | **171,617,487.98** | **80.4%** | **41,803,980.55** | **19.6%** |
| **Нийт зээлдэгчийн тоо** | **38,016** | **100.0%** | **22,529** | **59.3%** | **15,487** | **40.7%** |
| Иргэн | 37,932 | 99.8% | 22,461 | 99.7% | 15,471 | 99.9% |
| Эмэгтэй | 19,535 | 51.4% | 10,811 | 48.0% | 8,724 | 56.3% |
| Хуулийн этгээд | 84 | 0.2% | 68 | 0.3% | 16 | 0.1% |
| **Зээлдэгчдийн насжилт** | **37,932** | **100.0%** | **22,461** | **59.2%** | **15,471** | **40.8%** |
| 18-35 насны | 13,769 | 36.3% | 10,141 | 45.1% | 3,628 | 23.5% |
| 36-45 насны | 12,134 | 32.0% | 7,577 | 33.7% | 4,557 | 29.5% |
| 46-55 насны | 7,653 | 20.2% | 3,459 | 15.4% | 4,194 | 27.1% |
| 55-аас дээш | 4,376 | 11.5% | 1,284 | 5.7% | 3,092 | 20.0% |
| **Зээлдэгчдийн боловсрол** | **37,932** | **100.0%** | **22,461** | **59.2%** | **15,471** | **40.8%** |
| Дээд | 12,358 | 32.6% | 7,616 | 33.9% | 4,742 | 30.7% |
| Тусгай дунд | 8,502 | 22.4% | 5,999 | 26.7% | 2,503 | 16.2% |
| Бүрэн дунд | 10,678 | 28.1% | 5,897 | 26.3% | 4,781 | 30.9% |
| Дунд | 5,305 | 14.0% | 2,868 | 12.8% | 2,437 | 15.8% |
| Бага | 1,089 | 2.9% | 81 | 0.3% | 1,008 | 6.5% |

Тайлант улиралд ХЗХ-д 38,016 зээлдэгчийн 213,421,468.53 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 59.3 хувь буюу 22,529 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 80.4 хувь буюу 171,617,487.98 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 40.7 хувь буюу 15,487 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 19.6 хувь буюу 41,803,980.55 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.8 хувь буюу 37,932 нь хувь хүн /үүний 51.4 хувь буюу 19,535 нь эмэгтэй/, 0.2 хувь буюу 84 нь хуулийн этгээд байна.

1 зээлдэгчид ногдох дундаж зээл 5,614.0 мянган төгрөг байна.

*Хүснэгт 5:ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/*

| СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ | ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч | | ҮҮНЭЭС: Улаанбаатар хот | | Орон нутаг | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| **ХЗХ-дын тоо** | **209** | **100.0%** | **116** | **55.5%** | **93** | **44.5%** |
| Нийт хадгаламжийн үлдэгдэл | 203,585,911.18 | 100.0% | 168,924,083.46 | 83.0% | 34,661,827.71 | 17.0% |
| Нийт хадгаламж эзэмшигчийн тоо | 33,600 | 100.0% | 16,727 | 49.8% | 16,873.00 | 50.2% |
| Эмэгтэй | 22,156 | 65.9% | 12,516 | 74.8% | 9,640.00 | 57.1% |
| **Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл** | **5,333,264.16** | **2.6%** | **4,786,894.26** | **2.8%** | **546,369.91** | **1.6%** |
| Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо | 3,722 | 11.1% | 2,727 | 16.3% | 995 | 5.9% |
| Иргэн | 3,703 | 11.0% | 2,710 | 16.2% | 993 | 5.9% |
| Эмэгтэй | 2,194 | 6.5% | 1,616 | 9.7% | 578 | 3.4% |
| Хуулийн этгээд | 19 | 0.1% | 17 | 0.1% | 2 | 0.0% |
| **Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл** | **198,252,647.02** | **97.4%** | **164,137,189.21** | **97.2%** | **34,115,457.81** | **98.4%** |
| Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо | 29,878 | 88.9% | 14,000 | 83.7% | 15,878 | 94.1% |
| Эмэгтэй | 29,833 | 88.8% | 13,991 | 83.6% | 15,842 | 93.9% |
| Иргэн | 19,962 | 59.4% | 10,900 | 65.2% | 9,062 | 53.7% |
| Хуулийн этгээд | 45 | 0.1% | 9 | 0.1% | 36 | 0.2% |
| **Хадгаламж эзэмшигчдийн насжилт** | **33,536** | **100.0%** | **16,701** | **100.0%** | **16,835** | **100.0%** |
| 18-35 насны | 9,414 | 28.1% | 5,052 | 30.3% | 4,362 | 25.9% |
| 36-45 насны | 10,116 | 30.2% | 5,258 | 31.5% | 4,858 | 28.9% |
| 46-55 насны | 8,032 | 23.9% | 3,796 | 22.7% | 4,236 | 25.1% |
| 55-аас дээш | 5,974 | 17.8% | 2,595 | 15.5% | 3,379 | 20.1% |
| **Хадгаламж эзэмшигчдийн боловсрол** | **33,536** | **100.0%** | **16,701** | **100.0%** | **16,835** | **100.0%** |
| Дээд | 14,578 | 43.5% | 9,442 | 56.5% | 5,136 | 30.5% |
| Тусгай дунд | 5,036 | 15.0% | 2,646 | 15.8% | 2,390 | 14.2% |
| Бүрэн дунд | 8,088 | 24.1% | 3,198 | 19.2% | 4,890 | 29.1% |
| Дунд | 3,820 | 11.4% | 872 | 5.2% | 2,948 | 17.5% |
| Бага | 2,014 | 6.0% | 543 | 3.2% | 1,471 | 8.7% |

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 33,600 хадгаламж эзэмшигчийн 203,585,911.18 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 49.8 хувь буюу 16,727 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 83.0 хувь буюу 168,924,083.46 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 50.2 хувь буюу 16,873 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 17.0 хувь буюу 34,661,827.71 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 2.6 хувийг хугацаагүй хадгаламжтай, 97.4 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 33,536 нь хувь хүн /үүний 65.9 хувь буюу 22,156 нь эмэгтэй/, 0.2 хувь буюу 64 нь хуулийн этгээд байна.

1 хадгаламж, эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 6,059.1 мянган төгрөг байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 291,197,433.45 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.8 хувь буюу 35,222,546.58 мянган төгрөгөөр өсөж банкны зах зээлийн 0.7 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 27.4 хувь буюу 45,848,457.45 мянган төгрөг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 11.7 хувь буюу 21,402,070.57 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 9.3 хувь буюу 4,909,242.05 мянган төгрөг, нийт зарлага 7.6 хувь буюу 3,335,474.67 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 17.2 хувь буюу 1,573,767.39 мянган төгрөгөөр нэмэгдэж 10,748,669.00 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 6:ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/*

| Үндсэн үзүүлэлтүүд | 2020 оны IV улирал | 2021 оны IV улирал | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | дүн | хувь |
| **Нийт хөрөнгө** | 255,974,886.87 | 291,197,433.45 | 35,222,546.58 | 13.8% |
| Банкны зах зээлд эзлэх хувь | 0.7% | 0.7% | | |
| **Нийт зээл** | 167,573,011.08 | 213,421,468.53 | 45,848,457.45 | 27.4% |
| Банкны зах зээлд эзлэх хувь | 1.0% | 1.0% | | |
| **Нийт чанаргүй зээл** | 7,362,704.72 | 7,393,064.38 | 30,359.66 | 0.4% |
| Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь | 4.4% | 3.5% | -0.9% | -21.3% |
| Банкны зах зээлд эзлэх хувь | 0.5% | 0.4% | | |
| **Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж** | 182,183,840.61 | 203,585,911.18 | 21,402,070.57 | 11.7% |
| Банкны зах зээлд эзлэх хувь | 1.1% | 1.1% | | |
| **Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө** | 18,469,981.60 | 25,362,675.29 | 6,892,693.69 | 37.3% |
| **Нийт хоршоологчдын өмч** | 30,742,763.91 | 38,365,311.58 | 7,622,547.67 | 24.8% |
| **Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл** | 8,922,819.90 | 8,482,007.77 | -440,812.13 | -4.9% |
| Нийт орлого | 53,065,136.48 | 57,974,378.53 | 4,909,242.05 | 9.3% |
| Нийт зарлага | 43,890,234.86 | 47,225,709.53 | 3,335,474.67 | 7.6% |
| **Цэвэр орлого, алдагдал** | **9,174,901.61** | **10,748,669.00** | **1,573,767.39** | **17.2%** |

### 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 116 ХЗХ-ны нийт хөрөнгө 239,725,926.52 мянган төгрөг нь зах зээлийн 82.3 хувь, нийт зээл 171,617,487.98 мянган төгрөг нь зах зээлийн 80.4 хувь, нийт хадгаламж 168,924,083.46 мянган төгрөг нь зах зээлийн 83.0 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 хувь буюу 160,109.73 мянган төгрөгөөр буурч 6,737,846.63 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.9 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 2.1 хувь буюу 178,461.02 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 5.9 хувь буюу 2,535,666.20 мянган төгрөгөөр, нийт зарлага 4.0 хувь буюу 1,439,227.75 мянган төгрөгөөр, нийт цэвэр орлого 16.2 хувь буюу 1,096,438.46 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын 77 ХЗХ "Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ"-г байгуулсан байна.

*Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/*

| Үндсэн үзүүлэлтүүд | 2020 оны IV улирал | 2021 оны IV улирал | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | дүн | хувь |
| **Нийт хөрөнгө** | 215,928,793.82 | 239,725,926.52 | 23,797,132.70 | 11.0% |
| ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь | 84.4% | 82.3% | -2.0% | -2.5% |
| **Нийт зээл** | 137,263,611.63 | 171,617,487.98 | 34,353,876.35 | 25.0% |
| ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь | 81.9% | 80.4% | -1.5% | -1.8% |
| **Нийт чанаргүй зээл** | 6,897,956.36 | 6,737,846.63 | -160,109.73 | -2.3% |
| ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь | 93.7% | 91.1% | -2.6% | -2.7% |
| Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь | 5.0% | 3.9% | -1.1% | -21.9% |
| **Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж** | 156,143,645.41 | 168,924,083.46 | 12,780,438.05 | 8.2% |
| ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь | 85.7% | 83.0% | -2.7% | -3.2% |
| **Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө** | 13,168,060.26 | 19,408,701.82 | 6,240,641.56 | 47.4% |
| ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь | 71.3% | 76.5% | 5.2% | 7.3% |
| **Нийт хоршоологчдын өмч** | 24,619,202.49 | 30,617,867.40 | 5,998,664.91 | 24.4% |
| ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь | 80.1% | 79.8% | -0.3% | -0.3% |
| **Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл** | 8,584,368.79 | 8,405,907.77 | -178,461.02 | -2.1% |
| Нийт орлого | 42,998,194.93 | 45,533,861.13 | 2,535,666.20 | 5.9% |
| Нийт зарлага | 36,217,151.69 | 37,656,379.44 | 1,439,227.75 | 4.0% |
| **Цэвэр орлого, алдагдал** | **6,781,043.24** | **7,877,481.70** | **1,096,438.46** | **16.2%** |

## 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 93 ХЗХ-ны нийт хөрөнгө 51,471,506.93 мянган төгрөг нь зах зээлийн 17.7 хувь, нийт зээлийн үлдэгдэл 41,803,980.55 мянган төгрөг нь зах зээлийн 19.6 хувь, нийт хадгаламж 34,661,827.71 мянган төгрөг нь зах зээлийн 17.0 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 23.6 хувь буюу 2,373,575.86 мянган төгрөг, нийт зарлага 24.7 хувь буюу 1,896,246.92 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 19.9 хувь буюу 477,328.93 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,871,187.30 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн 31 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

*Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/*

| Үндсэн үзүүлэлтүүд | 2020 оны IV улирал | 2021 оны IV улирал | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | Дүн | хувь |
| **Нийт хөрөнгө** | 40,046,093.05 | 51,471,506.93 | 11,425,413.88 | 28.5% |
| ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь | 15.6% | 17.7% | 2.1% | 13.3% |
| **Нийт зээл** | 30,309,399.45 | 41,803,980.55 | 11,494,581.10 | 37.9% |
| ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь | 18.1% | 19.6% | 1.5% | 8.2% |
| **Нийт чанаргүй зээл** | 464,748.36 | 655,217.75 | 190,469.39 | 41.0% |
| ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь | 6.3% | 8.9% | 2.6% | 40.7% |
| Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь | 1.5% | 1.6% | 0.1% | 4.5% |
| **Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж** | 26,040,195.20 | 34,661,827.71 | 8,621,632.51 | 33.1% |
| ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь | 14.3% | 17.0% | 2.7% | 19.1% |
| **Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө** | 5,301,921.34 | 5,953,973.47 | 652,052.13 | 12.3% |
| ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь | 28.7% | 23.5% | -5.2% | -18.2% |
| **Нийт хоршоологчдын өмч** | 6,123,561.42 | 7,747,444.19 | 1,623,882.77 | 26.5% |
| ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь | 19.9% | 20.2% | 0.3% | 1.5% |
| **Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл** | 338,451.11 | 76,100.00 | -262,351.11 | -77.5% |
| Нийт орлого | 10,066,941.54 | 12,440,517.40 | 2,373,575.86 | 23.6% |
| Нийт зарлага | 7,673,083.17 | 9,569,330.09 | 1,896,246.92 | 24.7% |
| **Цэвэр орлого, алдагдал** | **2,393,858.37** | **2,871,187.30** | **477,328.93** | **19.9%** |

# ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

## 3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

*Хүснэгт 12: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/*

| ХӨРӨНГӨ | 2020 оны IV улирал | | 2021 оны IV улирал | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **Эргэлтийн хөрөнгө** | **251,616,752.84** | **98.3%** | **280,082,405.11** | **96.2%** | **28,465,652.27** | **11.3%** |
| **Мөнгөн хөрөнгө** | **77,670,083.10** | **30.3%** | **61,336,408.78** | **21.1%** | **-16,333,674.32** | **-21.0%** |
| Бэлэн мөнгө | 3,476,736.96 | 1.4% | 3,815,314.01 | 1.3% | 338,577.05 | 9.7% |
| Банкинд байршуулсан харилцах | 51,377,854.62 | 20.1% | 13,265,916.99 | 4.6% | -38,111,937.63 | -74.2% |
| Банкинд байршуулсан хадгаламж | 22,815,491.52 | 8.9% | 44,255,177.77 | 15.2% | 21,439,686.25 | 94.0% |
| **Богино хугацаат хөрөнгө оруулалт** | **100,000.00** | **0.0%** | **150,000.00** | **0.1%** | **50,000.00** | **50.0%** |
| Арилжааны үнэт цаас | 100,000.00 | 0.0% | 150,000.00 | 0.1% | 50,000.00 | 50.0% |
| **Зээл /цэврээр/** | **162,563,225.72** | **63.5%** | **207,849,100.05** | **71.4%** | **45,285,874.33** | **27.9%** |
| Нийт зээл | 167,573,011.08 | 65.5% | 213,421,468.53 | 73.3% | 45,848,457.45 | 27.4% |
| Хэвийн зээл | 154,667,866.45 | 60.4% | 202,122,837.16 | 69.4% | 47,454,970.71 | 30.7% |
| Хугацаа хэтэрсэн зээл | 5,542,439.91 | 2.2% | 3,905,566.98 | 1.3% | -1,636,872.93 | -29.5% |
| Чанаргүй зээл | 7,362,704.72 | 2.9% | 7,393,064.38 | 2.5% | 30,359.66 | 0.4% |
| (Зээлийн эрсдэлийн сан ) | 5,009,785.36 | 2.0% | 5,572,368.48 | 1.9% | 562,583.12 | 11.2% |
| **Авлага** | **9,376,201.73** | **3.7%** | **9,062,588.18** | **3.1%** | **-313,613.55** | **-3.3%** |
| Байгууллага, хүмүүсээс авах авлага | 1,784,413.83 | 0.7% | 740,635.24 | 0.3% | -1,043,778.59 | -58.5% |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 7,591,787.90 | 3.0% | 8,321,952.94 | 2.9% | 730,165.04 | 9.6% |
| **Бусад эргэлтийн хөрөнгө** | **869,229.59** | **0.3%** | **917,997.81** | **0.3%** | **48,768.22** | **5.6%** |
| **Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр/** | **1,038,012.71** | **0.4%** | **766,310.29** | **0.3%** | **-271,702.42** | **-26.2%** |
| Өмчлөх бусад хөрөнгө | 1,061,140.49 | 0.4% | 804,623.61 | 0.3% | -256,516.88 | -24.2% |
| (Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга) | 23,127.78 | 0.0% | 38,313.32 | 0.0% | 15,185.54 | 65.7% |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **4,358,134.03** | **1.7%** | **11,115,028.34** | **3.8%** | **6,756,894.31** | **155.0%** |
| **Үндсэн хөрөнгө /цэвэр/** | **4,146,230.56** | **1.6%** | **3,884,855.05** | **1.3%** | **-261,375.51** | **-6.3%** |
| Үндсэн хөрөнгө | 5,803,107.55 | 2.3% | 5,874,613.06 | 2.0% | 71,505.51 | 1.2% |
| (Хуримтлагдсан элэгдэл) | 1,656,877.00 | 0.6% | 1,989,758.02 | 0.7% | 332,881.02 | 20.1% |
| **Биет бус хөрөнгө** | **196,383.47** | **0.1%** | **7,214,685.50** | **2.5%** | **7,018,302.03** | **3573.8%** |
| Биет бус хөрөнгө | 263,400.06 | 0.1% | 7,330,374.39 | 2.5% | 7,066,974.33 | 2683.0% |
| (Биет бус хөрөнгийн элэгдэл) | 67,016.59 | 0.0% | 115,688.89 | 0.0% | 48,672.30 | 72.6% |
| **Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө** | **15,520.00** | **0.0%** | **15,487.79** | **0.0%** | **-32.21** | **-0.2%** |
| Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө | 15,520.00 | 0.0% | 15,487.79 | 0.0% | -32.21 | -0.2% |
| **Хөрөнгийн дүн** | **255,974,886.87** | **100.0%** | **291,197,433.45** | **100.0%** | **35,222,546.58** | **13.8%** |

*Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/*




2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 291,197,433.45 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.8 хувь буюу 35,222,546.58 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.2 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.8 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 21.1 хувийг, цэвэр зээл 71.4 хувийг тус тус эзэлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.4 хувь буюу 45,848,457.45 мянган төгрөгөөр өсөж 213,421,468.53 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,572,368.48 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 207,849,100.05 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.5 хувь буюу 1,636,872.93 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

*График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/*




## 3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 186,711,141.62 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 64.1 хувийг, 25,108 гишүүн нь нийт гишүүдийн 33.3 хувийг тус тус эзэлж байна.

*Хүснэгт 13: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/*

| № | Хөрөнгийн хэмжээ | ХЗХ-дын тоо | Нийт хөрөнгө | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Дүн | Хувь | Тоо | Хувь |
| 1 | 10,000,000.0-аас дээш | 4 | 186,711,141.62 | 64.1% | 25,108 | 33.3% |
| 2 | 1,000,000.0 - 10,000,000.0 | 24 | 69,864,425.64 | 24.0% | 22,559 | 29.9% |
| 3 | 500,000.0-1,000,000.0 | 18 | 12,575,784.03 | 4.3% | 7,459 | 9.9% |
| 4 | 100,000.0-500,000.0 | 77 | 16,793,470.35 | 5.8% | 12,957 | 17.2% |
| 5 | 50,000.0-100,000.0 | 55 | 4,264,951.26 | 1.5% | 5,462 | 7.2% |
| 6 | 10,000.0-50,000.0 | 30 | 986,610.55 | 0.3% | 1,835 | 2.4% |
| 7 | 10,000.0 хүртэл | 1 | 1,050.00 | 0.0% | 20 | 0.0% |
| | Нийт дүн | **209** | **291,197,433.45** | **100.0%** | **75,400** | **100.0%** |




## 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 213,421,468.53 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 73.3 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 207,849,100.05 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 71.4 хувийг тус тус эзэлж байна.Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.2 хувь байна. 1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 21 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 85.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант улиралд 2 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

*Хүснэгт 15: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/*

| № | Зээлийн хэмжээ | ХЗХ-дын тоо | Зээлийн дүн | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 1,000,000.0 дээш | 21 | 181,704,496.43 | 85.1% |
| 2 | 500,000.0-1,000,000.0 | 17 | 11,769,057.84 | 5.5% |
| 3 | 100,000.0-500,000.0 | 68 | 14,742,715.62 | 6.9% |
| 4 | 50,000.0-100,000.0 | 55 | 3,892,008.71 | 1.8% |
| 5 | 10,000.0-50,000.0 | 43 | 1,287,651.98 | 0.6% |
| 6 | 10,000.0 хүртэл | 3 | 25,537.94 | 0.0% |
| 7 | Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй | 2 | 0.00 | 0.0% |
| | **Нийт дүн** | **209** | **213,421,468.53** | **100%** |

## 3.4 Зээлийн чанарын талаар

*Хүснэгт 17: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/*

| Зээлийн ангиллын мэдээлэл | Зээлдэгчийн мэдээлэл | | Зээлийн үлдэгдэл | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| **Нийт** | **38,016** | **100.0%** | **213,421,468.53** | **100.0%** |
| Хэвийн | 35,861 | 94.3% | 202,122,837.16 | 94.7% |
| Хугацаа хэтэрсэн | 987 | 2.6% | 3,905,566.98 | 1.8% |
| Чанаргүй | 1,168 | 3.1% | 7,393,064.38 | 3.5% |
| *Хэвийн бус* | *438* | *37.5%* | 1,823,417.40 | *24.7%* |
| *Эргэлзээтэй* | *266* | *22.8%* | 1,433,833.34 | *19.4%* |
| *Муу* | *464* | *39.7%* | 4,135,813.64 | *55.9%* |

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 94.7 хувь буюу 202,122,837.16 мянган төгрөгийг хэвийн зээл, 1.8 хувь буюу 3,905,566.98 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.5 хувь буюу 7,393,064.38 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 11,298,631.36 мянган төгрөгийн үлдэгдэлд 49.3 хувь буюу 5,572,368.48 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 94.3 хувийг хэвийн, 2.6 хувийг хугацаа хэтэрсэн, 3.1 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,168 зээлдэгчийн 7,393,064.38 мянган төгрөгийн үлдэгдлийн 37.5 хувийг хэвийн бус, 22.8 хувийг эргэлзээтэй, 39.7 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

*График 8: Зээлийн чанар*




Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 пунктээр өсөж 94.7 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 1.5 пунктээр буурч 1.8 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.9 пунктээр буурч 3.5 хувьд хүрсэн байна.

*Хүснэгт 20: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/*

| № | ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ | Зээлийн эхний үлдэгдэл /дүн/ | Тайлант хугацаанд олгосон зээл | Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл | Зээлийн эцсийн үлдэгдэл | Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 5,074,506.25 | 14,616,373.82 | 12,217,381.40 | 7,473,498.67 | 3.5% |
| 2 | Уул уурхай, олборлолт | 1,917,745.55 | 1,953,143.98 | 1,734,443.48 | 2,136,446.05 | 1.0% |
| 3 | Боловсруулах үйлдвэрлэл | 1,701,558.74 | 2,347,503.44 | 2,516,663.14 | 1,532,399.04 | 0.7% |
| 4 | Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж | 349,345.42 | 220,689.52 | 273,791.01 | 296,243.93 | 0.1% |
| 5 | Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 412,482.36 | 939,901.00 | 887,169.79 | 465,213.56 | 0.2% |
| 6 | Барилга | 4,545,384.04 | 12,880,223.88 | 10,291,227.76 | 7,134,380.15 | 3.3% |
| 7 | Бөөний болон жижиглэн худалдаа | 14,863,395.42 | 27,875,564.81 | 26,279,011.35 | 16,459,948.87 | 7.7% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Машин мотоциклийн засвар үйлчилгээ | 1,214,589.30 | 1,625,716.26 | 1,278,457.25 | 1,561,848.31 | 0.7% |
| 9 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 1,052,655.72 | 3,433,767.58 | 2,107,802.87 | 2,378,620.43 | 1.1% |
| 10 | Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | 3,811,283.04 | 6,140,742.94 | 5,152,322.00 | 4,799,703.99 | 2.3% |
| 11 | Мэдээлэл холбоо | 379,125.12 | 4,757,983.50 | 1,282,352.85 | 3,854,755.76 | 1.8% |
| 12 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 4,405,580.71 | 30,289,779.10 | 19,596,468.37 | 15,098,891.44 | 7.1% |
| 13 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 2,234,510.14 | 2,348,200.94 | 2,638,518.80 | 1,944,192.28 | 0.9% |
| 14 | Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 66,782.55 | 346,880.00 | 49,706.25 | 363,956.30 | 0.2% |
| 15 | Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 264,116.31 | 122,299.00 | 203,450.63 | 182,964.68 | 0.1% |
| 16 | Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | 0 | 0 | 0 | 0 | 0.0% |
| 17 | Боловсрол | 1,017,422.70 | 2,590,928.58 | 2,379,497.46 | 1,228,853.81 | 0.6% |
| 18 | Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа | 942,880.40 | 1,366,758.12 | 1,295,469.17 | 1,014,169.35 | 0.5% |
| 19 | Бусад | 121,400,875.42 | 452,544,802.15 | 428,450,295.67 | 145,495,381.90 | 68.2% |
| | *Үүнээс: Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл* | *12,071,806.03* | *57,379,007.58* | *53,117,959.54* | *16,332,854.07* | 7.7% |
| | **НИЙТ** | **165,654,239.16** | **566,401,258.62** | **518,634,029.26** | **213,421,468.53** | **100.0%** |

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д нийт 566,401,258.62 мянган төгрөгийн зээл олгож, 518,634,029.26 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдэж 213,421,468.53 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг зээлийн бүтээгдэхүүнээр нь ангилахад нийт зээлийн үлдэгдлийн 68.2 хувь буюу 145,495,381.90 мянган төгрөгийг бусад, 7.7 хувь буюу 16,459,948.87 мянган төгрөгийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 7.1 хувь буюу 15,098,891.44 мянган төгрөгийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 3.5 хувь буюу 7,473,498.67 мянган төгрөгийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 3.3 хувь буюу 7,134,380.15 мянган төгрөгийн барилгын зориулалтаар тус тус авсан байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 7.7 хувь буюу 16,332,854.07 мянган төгрөгийг хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл эзэлж байна.

# ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

## 4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар

*Хүснэгт 21: ХЗХ-дын эх үүсвэрийн бүтэц (мянган төгрөгөөр)*

| ЭХ ҮҮСВЭР | 2020 IV улирал | | 2021 IV улирал | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **Өр төлбөр** | **206,503,733.55** | **80.7%** | **227,301,079.98** | **78.1%** | **20,797,346.43** | **10.1%** |
| **Хадгаламж** | **182,183,840.61** | **71.2%** | 203,585,911.18 | **69.9%** | **21,402,070.57** | **11.7%** |
| Хугацаагүй | 3,013,136.04 | 1.2% | 5,333,264.16 | 1.8% | 2,320,128.12 | 77.0% |
| Хугацаатай | 179,170,704.56 | 70.0% | 198,252,647.02 | 68.1% | 19,081,942.46 | 10.7% |
| **Богино хугацаат зээл** | **3,012,830.61** | **1.2%** | **6,386,596.17** | **2.2%** | **3,373,765.56** | **112.0%** |
| **Бусад богино хугацаат өр төлбөр** | **15,379,024.39** | **6.0%** | **15,108,609.35** | **5.2%** | **-270,415.04** | **-1.8%** |
| **Урт хугацаат өр төлбөр** | **5,928,037.95** | **2.3%** | **2,219,963.29** | **0.8%** | **-3,708,074.66** | **-62.6%** |
| **Өөрийн хөрөнгө** | **49,471,153.32** | **19.3%** | **63,896,353.47** | **21.9%** | **14,425,200.15** | **29.2%** |
| **Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө** | **18,469,981.60** | **7.2%** | 25,362,675.29 | **8.7%** | **6,892,693.69** | **37.3%** |
| Гишүүний оруулсан хувь хөрөнгө | 18,338,851.88 | 7.1% | 25,242,566.57 | 8.7% | 6,903,714.69 | 37.6% |
| Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө | 131,129.71 | 0.1% | 120,108.71 | 0.0% | -11,021.00 | -8.4% |
| **Дахин үнэлгээний нэмэгдэл** | **258,407.82** | **0.1%** | **168,366.60** | **0.1%** | **-90,041.22** | **-34.8%** |
| **Хоршоологчдын өмч** | **30,742,763.91** | **12.0%** | **38,365,311.58** | **13.2%** | **7,622,547.67** | **24.8%** |
| Нөөцийн сан | 8,147,678.98 | 3.2% | 9,540,672.69 | 3.3% | 1,392,993.71 | 17.1% |
| Хандив, тусламж | 524,007.25 | 0.2% | 326,332.53 | 0.1% | -197,674.72 | -37.7% |
| Хадгаламж, хамгаалалтын сан | 1,912,116.47 | 0.8% | 2,276,836.70 | 0.8% | 364,720.23 | 19.1% |
| Нийгмийн хөгжлийн сан | 749,111.79 | 0.3% | 833,124.19 | 0.3% | 84,012.40 | 11.2% |
| Тогтворжилтын сан | 1,909,446.65 | 0.7% | 2,220,780.46 | 0.7% | 311,333.81 | 16.3% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Бусад сангууд | 1,338,561.72 | 0.5% | 1,390,162.11 | 0.5% | 51,600.39 | 3.9% |
| Хуримтлагдсан орлого /алдагдал/ | 16,161,841.05 | 6.3% | 21,777,402.90 | 7.5% | 5,615,561.85 | 34.7% |
| Тайлангийн үеийн цэвэр орлого | 9,174,901.61 | 3.6% | 10,748,669.00 | 3.7% | 1,573,767.39 | 17.2% |
| Өмнөх үеийн цэвэр орлого | 6,986,939.44 | 2.7% | 11,028,733.90 | 3.8% | 4,041,794.46 | 57.8% |
| **Нийт өр төлбөр ба өөрийн** | **255,974,886.87** | **100.0%** | **291,197,433.45** | **100.0%** | **35,222,546.58** | **13.8%** |

Зах зээлийн нийт өр төлбөр 227,301,079.98 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1 хувь буюу 20,797,346.43 мянган төгрөгөөр, өөрийн хөрөнгө 63,896,353.47 мянган төгрөг нь 29.2 хувь буюу 14,425,200.15 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн бүтцийн 78.1 хувийг өр төлбөр, 21.9 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

*График 10: Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/*




ХЗХ-дын хоршоологчдын өмчийн хэмжээ 2017 оны 4 дүгээр улиралд 14.9 тэрбум төгрөг байсан бол 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 157.0 хувь буюу 23.4 тэрбум төгрөгөөр өсөж 38.3 тэрбум төгрөгт хүрсэн. Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 2017 оны мөн үед 99.3 тэрбум төгрөг байсан бол 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 104.9 хувь буюу 104.2 тэрбум төгрөгөөр өсөж 203.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

## 4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

ХЗХ-ны зах зээлийн татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 203,585,911.18 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 69.9 хувийг эзэлж байна. Нийт хадгаламжийн 97.4 хувийг хугацаатай хадгаламж, 2.6 хувийг хугацаагүй хадгаламж тус тус бүрдүүлж байна.

Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сарын 1.2 хувь байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн дүнгээр 10 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжтай 4 ХЗХ-ны хадгаламж нийт ХЗХ-дын хадгаламжийн дүнгийн 67.4 хувийг эзэлж байна. Тайлант улиралд 6 ХЗХ хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.

*Хүснэгт 22: ХЗХ-дын хадгаламж, интервалаар /мянган төгрөгөөр/*

| № | Хадгаламжийн хэмжээ | ХЗХ -д | Хадгаламжийн дүн | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **1** | 10,000,000.0 дээш | 4 | 137,156,074.31 | 67.4% |
| **2** | 1,000,000.0-10,000,000.0 | 18 | 44,788,967.77 | 22.0% |
| **3** | 500,000.0-1,000,000.0 | 8 | 5,287,907.85 | 2.6% |
| **4** | 100,000.0-500,000.0 | 51 | 12,438,490.46 | 6.1% |
| **5** | 50,000.0-100,000.0 | 26 | 2,037,386.11 | 1.0% |
| **6** | 10,000.0-50,000.0 | 67 | 1,709,573.45 | 0.8% |
| **7** | 5,000.0-10,000.0 | 16 | 129,333.90 | 0.1% |
| **8** | 5,000.0 хүртэл | 13 | 38,177.33 | 0.0% |
| **9** | Хадгаламжгүй | 6 | 0 | - |
| | **Нийт дүн** | **209** | **203,585,911.18** | **100%** |

*График 11: ХЗХ-нызах зээлийн хадгаламжийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/*




ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт хадгаламжийн хэмжээ сүүлийн 5 жилд дунджаар 20.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## 4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар

*Хүснэгт 24: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц (мянган төгрөгөөр)*

| БУСДААС АВСАН ЗЭЭЛ | 2020 IV улирал | | 2021 IV улирал | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **Богино хугацаат зээл** | **3,012,830.61** | **33.7%** | **6,386,596.17** | **74.2%** | **3,373,765.56** | **112.0%** |
| Банкнаас авсан зээл | 125,750.50 | 1.4% | 4,287,210.70 | 49.8% | 4,161,460.20 | 3309.3% |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээл | 607,125.22 | 6.8% | 523,000.00 | 6.1% | -84,125.22 | -13.9% |
| Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл | 2,279,954.89 | 25.5% | 1,576,385.47 | 18.3% | -703,569.42 | -30.9% |
| Тогтворжилтын сангийн туслалцаа | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат өр төлбөр** | **5,928,037.95** | **66.3%** | **2,219,963.29** | **25.8%** | **- 3,708,074.66** | **-62.6%** |
| Банкнаас авсан зээл | - | 0.0% | 16,100.00 | 0.2% | 16,100.00 | 100.0% |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээл | 2,299,095.16 | 25.7% | - | 0.0% | -2,299,095.16 | -100.0% |
| Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл | 3,610,894.14 | 40.4% | 2,079,311.61 | 24.2% | -1,531,582.53 | -42.4% |
| Тогтворжилтын сангийн туслалцаа | - | - | - | - | - | - |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 18,048.66 | 0.2% | 124,551.68 | 1.4% | 106,503.02 | 590.1% |
| **Нийт дүн** | **8,940,868.56** | **100.0%** | **8,606,559.45** | **100.0%** | **-334,309.10** | **-3.7%** |

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын бусдаас авсан зээлийн үлдэгдэл 8,606,559.45 мянган төгрөг байгаа нь зах зээлийн нийт хөрөнгийн 3.0 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 хувь буюу 334,309.10 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант улиралд бусдаас авсан нийт зээлийн 74.2 хувийг богино хугацаат зээл, 25.8 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус бүрдүүлж байна. Богино хугацаат зээлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 112.0 хувь буюу 3,373,765.56 мянган төгрөгөөр өсч, урт хугацаат өр төлбөр 62.6 хувь буюу 3,708,074.66 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна

*Хүснэгт 25: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц, хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/*

| БУСДААС АВСАН ЗЭЭЛ | Нийт | | УБ | | Орон нутаг | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| Банкнаас авсан зээл | 4,303,310.70 | 50.7% | 4,287,210.70 | 51.0% | 16,100.00 | 21.2% |
| Санхүүгийн байгууллагаас авсан зээл | 523,000.00 | 6.2% | 523,000.00 | 6.2% | 0.00 | 0.0% |
| Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл | 3,655,697.07 | 43.1% | 3,595,697.07 | 42.8% | 60,000.00 | 78.8% |
| **Нийт дүн** | **8,482,007.77** | **100.0%** | **8,405,907.77** | **100.0%** | **76,100.00** | **100.0%** |

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд банкнаас авсан зээл 50.7 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 6.2 хувь, төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 43.1 хувийг тус тус эзэлж байна.

## 4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар

Тайлант улиралд ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөр 15,108,609.35 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 270,415.04 мянган төгрөг буюу 1.8 хувиар буурсан бөгөөд зах зээлийн нийт хөрөнгийн 5.2 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 26: ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөрийн бүтэц /мянган төгрөгөөр/*

| БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2020 IV улирал | | 2021 IV улирал | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| Цалингийн өглөг | 125,558.43 | 0.8% | 129,777.27 | 0.9% | 4,218.84 | 3.4% |
| Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг | 1,003,517.46 | 6.5% | 1,252,328.18 | 8.3% | 248,810.72 | 24.8% |
| Ногдол ашгийн өглөг | 144,443.72 | 0.9% | 209,574.89 | 1.4% | 65,131.17 | 45.1% |
| Санхүүгийн түрээсийн өглөг | 0.00 | 0.0% | 16,281.84 | 0.1% | 16,281.84 | 100.0% |
| Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого | 0.00 | 0.0% | 95.36 | 0.0% | 95.36 | 100.0% |
| Урьдчилж орсон орлого | 64,135.31 | 0.4% | 87,546.21 | 0.6% | 23,410.89 | 36.5% |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 12,601,044.30 | 81.9% | 12,046,465.92 | 79.7% | -554,578.38 | -4.4% |
| Салбар хоорондын тооцоогоорх өглөг | 0.00 | 0.0% | 0.00 | 0.0% | 0.00 | - |
| Бусад богино хугацаат өглөг | 1,440,325.16 | 9.4% | 1,366,539.68 | 9.0% | -73,785.49 | -5.1% |
| **Нийт дүн** | **15,379,024.39** | **100.0%** | **15,108,609.35** | **100.0%** | **-270,415.04** | **-1.8%** |

## 4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ 25,362,675.29 мянган төгрөг нь нийт эх үүсвэрийн 8.7 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 27: ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/*

| № | Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ | ХЗХ-дын тоо | Гишүүдийн тоо | | Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн | | Нэг гишүүнд ногдох хувь хөрөнгө |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн |
| 1 | 1,000,000.0 дээш | 3 | 24,404 | 32.4% | 12,053,776.42 | 47.5% | 493.93 |
| 2 | 500,000.0-1,000,000.0 | 5 | 3,755 | 5.0% | 3,161,880.81 | 12.5% | 842.05 |
| 3 | 100,000.0-500,000.0 | 23 | 18,422 | 24.4% | 5,401,127.70 | 21.3% | 293.19 |
| 4 | 50,000.0-100,000.0 | 29 | 9,854 | 13.1% | 1,975,463.79 | 7.8% | 200.47 |
| 5 | 10,000.0-50,000.0 | 100 | 15,511 | 20.6% | 2,456,428.03 | 9.7% | 158.37 |
| 6 | 5,000.0-10,000.0 | 37 | 2,928 | 3.9% | 272,178.62 | 1.1% | 92.96 |
| 7 | 5,000.0 хүртэл | 12 | 526 | 0.7% | 41,819.93 | 0.2% | 79.51 |
| | **Нийт дүн** | **209** | **75,400** | **100%** | **25,362,675.29** | **100%** | **340.43** |




Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн өндөр 10 ХЗХ-ны мэдээллийг зах зээлийн нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээтэй харьцуулахад 69.5 хувийг эзэлж байна.

## 4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 63,896,353.47 мянган төгрөгт хүрч, нийт эх үүсвэрийн 21.9 хувийг эзэлж байна.

Тайлант улиралд 12 ХЗХ-ны нийт өр төлбөрийн хэмжээ нийт хөрөнгөөс хэтэрсэн буюу өөрийн хөрөнгөгүй болсон ба 11 ХЗХ нь "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд байгуулагдсан байна.

*Хүснэгт 29: ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/*

| № | Өөрийн хөрөнгийн хэмжээ | ХЗХ-дын тоо | Өөрийн хөрөнгө | |
|---|---|---|---|---|
| | | | Дүн | Хувь |
| 1 | 1,000,000.0 дээш | 7 | 41,820,121.07 | 65.4% |
| 2 | 500,000.0-1,000,000.0 | 14 | 9,514,931.35 | 14.9% |
| 3 | 100,000.0-500,000.0 | 39 | 7,589,540.63 | 11.9% |
| 4 | 50,000.0-100,000.0 | 41 | 2,994,141.62 | 4.7% |
| 5 | 10,000.0-50,000.0 | 80 | 2,123,373.71 | 3.3% |
| 6 | 10,000.0 доош | 16 | 97,524.05 | 0.2% |
| 7 | Өөрийн хөрөнгөгүй | 12 | -232,708.45 | -0.4% |
| | **Нийт дүн** | **209** | **63,896,353.47** | **100%** |

*Хүснэгт 31: ХЗХ-дын хоршоологчдын өмч, интервалаар /мянган төгрөгөөр/*

| № | Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Хоршоологчдын өмчийн дүн | |
|---|---|---|---|---|
| | | | Дүн | Хувь |
| **1** | 1,000,000.0 дээш | 3 | 24,633,194.35 | 64.2% |
| **2** | 500,000.0-1,000,000.0 | 4 | 2,915,312.83 | 7.6% |
| **3** | 100,000.0-500,000.0 | 28 | 7,248,331.72 | 18.9% |
| **4** | 50,000.0-100,000.0 | 29 | 2,126,021.73 | 5.5% |
| **5** | 10,000.0-50,000.0 | 70 | 1,611,773.48 | 4.2% |
| **6** | 5,000.0-10,000.0 | 24 | 170,524.91 | 0.4% |
| **7** | 1,000.0-5,000.0 | 27 | 80,324.33 | 0.2% |
| **8** | 1,000.0 хүртэл | 5 | 1,814.52 | 0.0% |
| **9** | Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/ | 19 | -421,986.28 | -1.1% |
| | **Нийт дүн** | **209** | **38,365,311.58** | **100%** |

Тайлант улиралд нийт 19 ХЗХ алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 ХЗХ буюу 65.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

# ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

## 5.1 ХЗХ-дын орлогын талаар

Тайлант улиралд зах зээлийн нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.3 хувь буюу 3,700,757.95 мянган төгрөгөөр нэмэгдэж 54,215,900.41 мянган төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 93.5 хувь хүүгийн орлого, 2.2 хувь үйл ажиллагааны бусад орлого, 4.3 хувийг үйл ажиллагааны бус орлого тус тус бүрдүүлж байна.

Зээлийн хүүгийн орлого 50,804,579.35 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.1 хувь буюу 1,990,352.34 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 32: ХЗХ-дын орлогын бүтэц(мянган төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2020.IV | | 2021.IV | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **1. Хүүгийн орлого** | **50,515,142.46** | **95.2%** | **54,215,900.41** | **93.5%** | **3,700,757.95** | **7.3%** |
| Зээлийн хүүгийн орлого | 48,814,227.01 | 92.0% | 50,804,579.35 | 87.6% | 1,990,352.34 | 4.1% |
| Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого | 252,697.95 | 0.5% | 215,778.25 | 0.4% | -36,919.70 | -14.6% |
| Үнэт цаасны хүүгийн орлого | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого | 1,600,415.77 | 3.0% | 3,309,286.11 | 5.7% | 1,708,870.33 | 106.8% |
| Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого | 16,997.24 | 0.0% | 63,760.16 | 0.1% | 46,762.92 | 275.1% |
| (Зээлийн хүүгийн орлогын буцаалт) | 169,195.52 | 0.3% | 177,503.46 | 0.3% | 8,307.94 | 4.9% |
| **2. Үйл ажиллагааны бусад орлого** | **1,016,329.54** | **1.9%** | **1,297,916.18** | **2.2%** | **281,586.64** | **27.7%** |
| **3. Үйл ажиллагааны бус орлого** | **1,533,664.48** | **2.9%** | **2,460,561.94** | **4.3%** | **926,897.46** | **60.4%** |
| **Нийт орлого** | **53,065,136.48** | **100.0%** | **57,974,378.53** | **100.0%** | **4,909,242.05** | **9.3%** |

## 5.2 ХЗХ-дын зардлын талаар

ХЗХ-ны зах зээлийн нийт зардлын хэмжээ 47,225,709.53 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.6 хувь буюу 3,335,474.67 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд хүүгийн зардал 67.6 хувь, үйл ажиллагааны зардал 25.8 хувь, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 4.2 хувь, үйл ажиллагааны бус зардал 0.6 хувийг тус тус эзэлж байна.

Хүүгийн зардал 31,921,953.76 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувь буюу 2,636,611.72 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 33: ХЗХ-дын зардлын бүтэц /мянган төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2020.IV | | 2021.IV | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **1.Хүүгийн зардал** | **29,285,342.04** | **66.7%** | **31,921,953.76** | **67.6%** | **2,636,611.72** | **9.0%** |
| Хадгаламжийн хүүгийн зардал | 28,812,258.22 | 65.6% | 31,342,974.81 | 66.4% | 2,530,716.59 | 8.8% |
| Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал | 443,063.94 | 1.0% | 423,060.75 | 0.9% | -20,003.19 | -4.5% |
| Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал | 0.00 | 0.0% | 543.00 | 0.0% | 543.00 | 100.0% |
| Бусад хүүгийн зардал | 60,931.40 | 0.1% | 182,961.80 | 0.4% | 122,030.40 | 200.3% |
| (Хүүгийн зардлын буцаалт) | 30,911.52 | 0.1% | 27,586.60 | 0.1% | -3,324.92 | -10.8% |
| **2. Болзошгүй эрсдэлийн сангийн зардал** | **2,059,380.18** | **4.7%** | **1,975,028.75** | **4.2%** | **-84,351.43** | **-4.1%** |
| Зээлийн эрсдэлийн зардал | 2,376,267.15 | 5.4% | 2,155,466.45 | 4.6% | -220,800.70 | -9.3% |
| Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал | 26,607.27 | 0.1% | 20,049.43 | 0.0% | -6,557.84 | -24.6% |
| (Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт) | 343,494.25 | 0.8% | 200,487.13 | 0.4% | -143,007.11 | -41.6% |
| **3. Үйл ажиллагааны зардал** | **11,540,389.71** | **26.3%** | **12,199,119.75** | **25.8%** | **658,730.04** | **5.7%** |
| Боловсон хүчний зардал | 7,368,513.50 | 16.8% | 7,682,721.37 | 16.3% | 314,207.87 | 4.3% |
| Бусад төрлийн зардал | 4,171,876.21 | 9.5% | 4,516,398.38 | 9.6% | 344,522.18 | 8.3% |
| **4. Үйл ажиллагааны бус зардал** | **141,551.13** | **0.3%** | **262,479.44** | **0.6%** | **120,928.31** | **85.4%** |
| **Татварын зардал** | **863,571.80** | **2.0%** | **867,127.82** | **1.8%** | **3,556.03** | **0.4%** |
| **Нийт зардал** | **43,890,234.86** | **100.0%** | **47,225,709.53** | **100.0%** | **3,335,474.67** | **7.6%** |
| **Цэвэр орлого** | **9,174,901.61** | **100.0%** | **10,748,669.00** | **100.0%** | **1,573,767.39** | **17.2%** |

## 5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт орлого 57,974,378.53 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.3 хувь буюу 4,909,242.05 мянган төгрөгөөр, нийт зардал 47,225,709.53 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.6 хувь буюу 3,335,474.67 мянган төгрөгөөр, цэвэр орлого 10,748,669.00 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.2 хувь буюу 1,573,767.39 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 34: ХЗХ-дын ашигт ажиллагаа /мянган төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2020.IV | 2021.IV |
|---|---|---|
| Нийт орлого | 53,065,136.48 | 57,974,378.53 |
| Нийт зардал | 43,890,234.86 | 47,225,709.53 |
| Нийт орлогод эзлэх нийт зардлын хувь | **82.7%** | **81.5%** |
| Цэвэр орлого | 9,174,901.61 | 10,748,669.00 |
| Нийт орлогод эзлэх цэвэр орлогын хувь | **17.3%** | **18.5%** |

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт орлогын 81.5 хувийг зардал, 18.5 хувийг цэвэр орлого эзлэх бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогод эзлэх зардлын хувь хэмжээ 1.2 хувиар буурч, цэвэр орлогын эзлэх хувь өссөн үзүүлэлттэй байна.

*График 12: ХЗХ-дын ашигт ажиллагаа /хувиар/*




ХЗХ-ны зах зээлийн нийт орлого сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

*График 13: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/*



## ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын 2021 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан /2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1022 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/ "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт"-ийг тооцоход дараах байдалтай байна.

### 6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

*Хүснэгт 39: ХЗХ-дын шалгуур үзүүлэлт хангасан байдал*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | БАЙВАЛ ЗОХИХ | Хангаагүй ХЗХ-дын тоо | Хувь |
|---|---|---|---|---|
| | **Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт** | | | |
| 1 | Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу) | 68,505.46 мян.төг | 49 | 23.4% |
| 2 | Чанаргүй зээлийн зохистой харьцаа | 5%-аас хэтрэхгүй | 30 | 14.4% |
| 3 | Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 21 | 10.0% |
| 4 | Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 2 | 1.0% |
| | **Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт** | | | |
| 1 | Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа | 60%-85% | 65 | 31.1% |
| 2 | Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 7 | 3.3% |
| 3 | Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа | 20%-80% | 36 | 17.2% |
| 4 | Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 40 | 19.1% |
| 5 | Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 4 | 1.9% |
| 6 | Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа | 5%-аас доошгүй | 44 | 21.1% |
| 7 | Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ | 3%-аас доошгүй | 70 | 33.5% |
| 8 | Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ | - | 31 | 14.8% |
| 9 | Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ | - | 38 | 18.2% |
| | **Зардлын зохистой хэмжээ** | | | |
| 11 | Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 52 | 24.9% |
| | **Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар** | | | |
| 12 | Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа | 4%-аас доошгүй | 43 | 20.6% |
| | **Өгөөж, зардлын хувь хэмжээ** | | | |
| 13 | Хөрөнгө /актив/-ийн өгөөж | | | 3.7% |

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ХЗХ-дын 23.4 хувь буюу 49 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 68,505.46 мянган төгрөгөөр илүү байгуулсан байна. Нийт ХЗХ-дын 14.4 хувь буюу 30 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцаа, 31.1 хувь буюу 65 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 17.2 хувь буюу 36 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 19.1 хувь буюу 40 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 21.1 хувь буюу 44 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 24.9 хувь буюу 52 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 20.6 хувь буюу 43 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

ХЗХ-ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 3.7 хувь байна. Тайлант улиралд зохистой харьцааг хангаж ажиллаагүй тохиолдолд Хорооноос тухайн ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба хөрөнгө, эх үүсвэрийн 6 зохистой харьцааг ХЗХ-дын 39.7 хувь буюу 83 ХЗХ бүрэн хангаж ажилласан байна.

*Хүснэгт 40: Эх үүсвэрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд*

| № | Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт | ХЗХ-дын тоо | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан | 83 | 39.7% |
| 2 | 1 ЗХШҮ хангаагүй | 67 | 32.1% |
| 3 | 2 ЗХШҮ хангаагүй | 31 | 14.8% |
| 4 | 3 ЗХШҮ хангаагүй | 19 | 9.1% |
| 5 | 4 ЗХШҮ хангаагүй | 9 | 4.3% |
| 6 | 5 ЗХШҮ хангаагүй | 0 | 0.0% |
| | **Нийт дүн** | **209** | **100%** |

## ДОЛОО. ДҮГНЭЛТ

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 209 ХЗХ хамрагдсанаас 14 ХЗХ-г өмнөх улирлын тайлангаар нэгтгэсэн болно.

- ХЗХ-дын статистик үзүүлэлт

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 209 ХЗХ 63 салбар, 741 ажилтантай, 75,400 гишүүн /75,199 иргэн, 201 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт 209 ХЗХ-ны эрхэлж буй санхүүгийн бусад ажил үйлчилгээг авч үзвэл тайлант хугацаанд 30.6 хувь буюу 64 ХЗХ төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх, 1.9 хувь буюу 4 ХЗХ санхүүгийн түрээсийн үйлчилгээ, 2.4 хувь буюу 5 ХЗХ даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх, 0.5 хувь буюу 1 ХЗХ мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байна. Төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй 64 ХЗХ-ны 3 ХЗХ нь орон нутгийн ХЗХ-д, 61 нь "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр"-т хамрагдсан ХЗХ-д байна. "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр"-ийн ХЗХ-дын 27.9 хувь буюу 17 ХЗХ төслийн зээлийн үлдэгдлийг бүрэн төлж дууссан байна.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 3.8 хувь буюу 2,749 гишүүнээр нэмэгдэж 75,400 гишүүнтэй болсон байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн тоо 44,575 буюу нийт гишүүдийн 59.1 хувь, орон нутгийн ХЗХ-дын гишүүдийн тоо 30,825 буюу нийт гишүүдийн 40.9 хувийг эзэлж байна.

Нийт ХЗХ-дын 45.0 хувь буюу 94 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 ХЗХ буюу 5.6 хувиар нэмэгдсэн байна.

- Зах зээлийн санхүүгийн үзүүлэлт

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 291,197,433.45 мянган төгрөг нь банкны зах зээлийн 0.7 хувь, нийт зээл 213,421,468.53 мянган төгрөг нь банкны зах зээлийн 1.0 хувь, чанаргүй зээл 7,393,064.38 мянган төгрөг нь банкны зах зээлийн 0.4 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 203,585,911.18 мянган төгрөг нь банкны зах зээлийн 1.1 хувийг тус тус эзэлж байна.

ХЗХ-дын гишүүдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгө 25,362,675.29 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 8.7 хувь, хоршоологчдын өмч 38,365,311.58 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 13.2 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд зах зээлийн хэмжээнд 57,974,378.53 мянган төгрөгийн орлого, 47,225,709.53 мянган төгрөгийн зардал, 10,748,669.00 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна. Цэвэр орлогын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 17.2 хувь буюу 1,573,767.39 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

2021 оны 4 дүгээр улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хөрөнгө 13.8 хувь буюу 35,222,546.58 мянган төгрөгөөр, нийт хадгаламжийн хэмжээ 11.7 хувь буюу 21,402,070.57 мянган төгрөгөөр, нийт зээлийн үлдэгдэл 27.4 хувь буюу 45,848,457.45 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын нийт хөрөнгө 5,897,569.95 мянган төгрөг буюу 2.0 хувь, нийт зээл 4,615,571.69 мянган төгрөг буюу 2.2 хувь, чанаргүй зээл 266,314.73 мянган төгрөг буюу 3.6 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 1,872,163.35 мянган төгрөг буюу 0.9 хувийг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд тус ХЗХ-д 1,209,899.83 мянган төгрөгийн орлого, 1,129,567.57 мянган төгрөгийн зардалтай

ажиллаж 80,332.26 мянган төгрөгийн цэвэр орлоготой тайлагнасан байна.

Харин “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын хувьд зах зээлийн хэмжээнд нийт хөрөнгө 14,044,343.34 мянган төгрөг буюу 4.8 хувь, нийт зээл 11,347,655.97 мянган төгрөг буюу 5.3 хувь, чанаргүй зээл 125,226.44 мянган төгрөг буюу 1.7 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 9,926,469.32 мянган төгрөг буюу 4.9 хувийг тус тус эзэлж байна. Тайлант улиралд уг төслийн хүрээнд байгуулагдсан 29 ХЗХ 3,007,364.01 мянган төгрөгийн орлого, 2,250,649.00 мянган төгрөгийн зардал, 756,715.00 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна.

- Хөрөнгийн бүтэц, зээлийн үйл ажиллагаа

Тайлант улиралд цэвэр зээлийн үлдэгдэл 207,849,100.05 мянган төгрөгт хүрч, зах зээлийн нийт хөрөнгийн 71.4 хувийг бүрдүүлж байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгөд хэвийн зээлийн үлдэгдэл 202,122,837.16 мянган төгрөг нь 69.4 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 3,905,566.98 мянган төгрөг нь 1.3 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 7,393,064.38 мянган төгрөг нь 2.5 хувийг тус тус эзэлж байна. ХЗХ-ны зах зээлийн чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30,359.66 мянган төгрөг буюу 0.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгө

ХЗХ-дын нийт өр төлбөр болон өөрийн хөрөнгийн 69.9 хувь буюу 203,585,911.18 мянган төгрөгийг хадгаламж, 6.0 хувь буюу 17,328,572.64 мянган төгрөгийг урт, богино хугацаат өр төлбөр, 8.7 хувь буюу 25,362,675.29 мянган төгрөгийг гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, 13.2 хувь буюу 38,365,311.58 мянган төгрөгийг хоршоологчдын өмч тус тус бүрдүүлж байна.

ХЗХ-дын гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн 97.4 хувь буюу 198,252,647.02 мянган төгрөгийг хугацаатай хадгаламж, 2.6 хувь буюу 5,333,264.16 мянган төгрөгийг хугацаагүй хадгаламж эзэлж байна.

- Орлого, зарлага

Тайлант хугацаанд ХЗХ-ны зах зээлийн нийт орлогын 93.5 хувь буюу 54,215,900.41 мянган төгрөгийг хүүгийн орлого, 2.2 хувь буюу 1,297,916.18 мянган төгрөгийг үйл ажиллагааны бусад орлого, 4.3 хувь буюу 2,460,561.94 мянган төгрөгийг үйл ажиллагааны бус орлого, нийт зардлын 67.6 хувь буюу 31,921,953.76 мянган төгрөгийг хүүгийн зардал, 25.8 хувь буюу 12,199,119.75 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардал тус тус бүрдүүлж байна. ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд цэвэр орлого 10,748,669.00 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.2 хувь буюу 1,573,767.39 мянган төгрөгөөр өссөн бөгөөд ХЗХ-дын 19.2 хувь буюу 33 ХЗХ 436,836.54 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Тайлант хугацаанд зах зээлийн хэмжээнд Хорооноос тогтоосон зайлшгүй хангах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ХЗХ-дын 39.7 хувь буюу 83 ХЗХ бүрэн хангаж ажилласан бөгөөд 31.1 хувь буюу 65 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 21.1 хувь буюу 44 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 17.2 хувь буюу 36 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 33.5 хувь буюу 70 ХЗХ нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээг, 20.6 хувь буюу 43 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. ХЗХ-ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 3.7 хувь байна.

“Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын 32.1 хувь

буюу 18 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 67.9 хувь буюу 38 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 50.0 хувь буюу 28 ХЗХ үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 41.1 хувь буюу 23 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа, 44.6 хувь буюу 25 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа болон хоршоологчдын өмчийн зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. Тус ХЗХ-дын хөрөнгийн өгөөж 1.4 хувьтай байна.